



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 8140

Арвайхээр

### Г Зардал хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XIII.4.1.1 дугаартай “Боловсрол, шинжлэх ухааны салбарын тоног төхөөрөмж /Өвөрхангай/ төсөл арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 359 дүгээр тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/430 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны салбарын тоног төхөөрөмж (Өвөрхангай)-д зарцуулах 400,000,000 (дөрвөн зуун сая) төгрөгийн хөтөлбөр, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (З.Балданням)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



6222 11 0085

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2022 оны  
дүгээр сарын .....-ны өдрийн  
дугаар захирамжийн  
хавсралт

Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсвийн багцад  
батлагдсан хуулийн XIII.4.1.1 дугаартай Өвөрхангай аймгийн Засаг даргад  
эрх шилжсэн дугаартай боловсрол, шинжлэх ухааны салбарын  
тоног төхөөрөмж /Өвөрхангай/ зардлын хуваарилалт

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
1	Сумдын Ерөнхий боловсролын сургуульд ангийн самбар	37,500,000
2	Зарим сумдын Ерөнхий боловсролын сургуульд Физик, Хими, Технологи, Англи хэлний кабинетийн тоног төхөөрөмж	184,000,000
3	Зарим сумдын Ерөнхий боловсролын сургуульд гал тогооны тоног төхөөрөмж	66,000,000
4	Шинээр ашиглалтад орох Ерөнхий боловсролын сургуульд сургачийн ширээ, сандал	112,500,000
	НИЙТ ДҮН	400,000,000

-оОо-